



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/274

Зуунмод

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт  
шилжүүлсэн хугацааг сунгасантай  
холбогдуулан авах зарим арга  
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 104 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан түр журам, Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 104 дүгээр тогтоолыг дагуу 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00:00 цагаас 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэл бүх нийтийн бэлэн байдал /Улаан түвшин/-д үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2. Бүх нийтийн бэлэн байдлын IV зэрэг буюу “Улаан түвшин”-д шилжсэн хугацаанд нутаг дэвсгэрийн хэмжээнд зөвшөөрөгдсөнөөс бусад төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлан, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмийг тогтоож, үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн төрийн байгууллага, хуулийн этгээд, хүний үйл ажиллагаанд онцгой дэглэм, тусгай шаардлага горимыг чанд мөрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Аймгийн нутаг дэвсгэрт албан байгууллагын өрөө тасалгаа, байр, орон сууцны орц, хонгил, цонх, хаалга, нийтийн бие засах газар, нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбай зэрэг халдвар тархах эрсдэл бүхий орчныг халдваргүйтгэх ажлыг эрчимжүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), Мал эмнэлгийн газар (Б.Болдбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Коронавируст /Ковид-19/ халдварын цар тахал сумдад батлагдсантай холбогдуулан сумын Эрүүл мэндийн төвүүд ор нэмэлтээр дэлгэх, вакцинжуулалтын бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу бэлэн байдлыг хангаж, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын бодис, эм эмнэлгийн хэрэгсэл, түргэвчилсэн оношлуур, PCR шинжилгээний оношлуурыг татан авч нөөц бүрдүүлэхийг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.



5. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан халдварын голомт бүхий сумдад хавьтал тогтоох, тандалт судалгааг эрчимжүүлэх, эрт илрүүлэх зохион байгуулалтын бүх талын арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

6. Улаанбаатар хот, бусад аймаг, өөрийн аймгийн сумдаас орон нутагт зорчих хөдөлгөөнийг зөвхөн хүндэтгэн үзэх шалтгаан /Эрүүл мэнд, буяны ажил/-тай иргэд, зайлшгүй шаардлагатай ачаа тээвэр /Хүнс, шатахуун, өвс, тэжээл, эм эмнэлгийн хэрэгсэл, уул уурхай, газар тариалан/ тээвэрчдийг “Бүх нийтийн бэлэн байдал” зарласан хугацаанд зөвхөн аймгийн онцгой комиссын шийдвэр, халдвар бүртгэгдсэн газраас PCR шинжилгээний хариуг үндэслэн, түргэвчилсэн шинжилгээ авч халдвар хамгааллын дэглэмийг хатуу мөрдүүлэн нэвтрүүлж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар), Төв аймаг дахь Цагдаагийн газар (Б.Ганзориг), Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Зайлшгүй шалтгаанаар сумдад ирж байгаа иргэдийг сумын онцгой комиссын шийдвэрээр 7 хоног гэрийн тусгаарлалтад ажиглан, хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

8. Оршуулга, буяны үйл ажиллагаанд оролцсон иргэдээс халдвар тархах эрсдэл өндөр байгаа тул тодорхой хязгаарлалт, хүний тоог зааж зохион байгуулах талаар иргэдэд зөвлөмж, анхааруулга өгч, хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

9. Иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор оршин суугаа газрын гадна талбай, цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайд алхах, дугуй унах, биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийхийг хатуу хязгаарлахгүйгээр хүн хоорондын зайг хатуу барих, нэг дор 3-аас илүү хүн цуглахгүй /гэр бүлийн хүрээнээс бусад/ байх талаар иргэдэд тогтмол мэдээлж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Ганзориг), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

10. “Улаан түвшин”-д шилжсэн хугацаанд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож, түүнд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллахыг Төв аймаг дахь Цагдаагийн газар (Б.Ганзориг), Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

11. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, иргэдэд зөвлөмж, зөвлөгөө өгөх зорилгоор орон нутгийн телевиз, цахим мэдээллийн хэрэгсэлээр тогтсон цагт өдөр бүр 30 минутаас доошгүй хугацаанд тусгай нэвтрүүлэг, контент бэлтгэж түгээх, эмчилгээний талаар зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах алба (С.Цогбаяр), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

12. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн А/239 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

13. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга (Н.Төмөрбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР